



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/157

Мөрөн сум

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний
дуудлага худалдааг дахин зохион
байгуулах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар хуралдааны 32 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 2024 оны 11 дугаар сарын 05-ны өдрийн 09⁰⁰-15⁰⁰ цагийн хооронд цахимаар зохион байгуулсугай.
2. Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газруудын байршил, зориулалт, хэмжээ, анхны үнэ, дэнчингийн хэмжээ зэргийг хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохих хууль тогтоомжийн дагуу баримт бичгийг бүрдүүлж зохион байгуулахыг газрын даамлыг түр орлон гүйцэтгэгч /Г.Банзрагч/-д даалгасугай.
4. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны А/126 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЦООЖ